

Германы хэлц үгийг монгол хэлнээ орчуулахдаа үгчлэн буулгах уу, дүйцүүлэн орлуулах уу?

А. Цэрэнчулуун*

Сэдвийн гол агуулга, үр дүнг тусгасан товчлол

Алив хэлний өвөрмөц хэлц үг эрт цагт үүсч бий болоод түүхэн урт хугацаанд анхны утгаа алдан өөр утгатай болох, тэрчлэн зарим үг нь хүртэл адил төстэй өөр үгээр солигдох тал хааяа гардаг байна. Энд адилаатар дуудлагатай үг тун их нөлөөлдөг бололтой.

Өвөрмөц хэлц үг дараах онцлогтой:

- бүтэн өгүүлбэр байдаггүй,
- хэлц үг нь утга муутай, бас доторхи үгс нь хэлэх гэсэн санаанаасаа өөр утгатай байдаг.

Хэлц үгийн дүрслэлийн байдал, агуулгаар нь түүний гарал үүслийг тааварлан олж болох бөгөөд энэ нь уг хэлцийг зөв ойлгоход чухал үүрэгтэй. Үгийг биш утгыг орчуулдаг гэсэн үг байдаг нь өвөрмөц хэлц үг дээр бүр ч онож хэлсэн үг болой.

Угаас алив яриаг хэлмэрчилж, ямар нэг сэдвийг орчуулахдаа дараах гурван зарчмыг мөрдлөгөө болгоно.

- эх текстийн утга санааг үнэн зөв гаргах,
- орчуулгын хэллэг нь уншигчтай, яруу сайхан хэллэгтэй байх,
- боломжтой бол орчуулахдаа үг нэмэхгүй, үг гээж орхигдуулахгүй байх.

Зөвхөн гадаад хэлний хэлц үгээр зогсохгүй төрөлх хэлнийхээ хэлц үгийг судлан зөв ойлгох нь чухал юм. Янз бүрийн хэлэнд төстэй буюу адил хэлц үг байдаг. Тухайлбал:

“Бэлгийн морины шүдийг үздэггүй” гэсэн хэлц үг герман, монгол хэлний аль алинд нь байдаг. Чухам хаанаас нь гаралтай болохыг мэдэхгүй. Ийм хэлц үгийг зөвхөн орчуулахад л хүрэлцээтэй. Өөр тохирох хэлц үгээр дүйцүүлэх шаардлагагүй. Өөр нэг жишээ авъя. Герман хэлэнд “могой загас шиг гөлчигнөсөн” гэсэн хэлц үг байдаг. Могой загас шиг хүн гэж ямар ч юмнаас бултаж орхидог зальтай хүнийг хэлнэ. Иймэрхүү хүнийг монгол хүн “олби огтоно шиг бултамтгай” гэж хэлнэ. Өөр нэг жишээ авъя,

*Орчуулагч, судлаач

“хоолны сайхныг идэн байж мэддэг” гэсэн германы хэлц үг бий. Хоолтой холбогдон энэ хэлц үг гарсан бололтой. Гэхдээ энэ хэлц үгийг шилжүүлэн одоо ямар нэг ажил дээр хэлдэг болсон байна. Гэтэл энэ нь монгол хүнд жаахан ойлгомжгүй санагдана. Тэгэхлээр өөр хэлц үгээр дүйцүүлэх хэрэг гарна. Гэтэл дүйцүүлэг олох нь бас ч хялбар бус.

Монгол хүн бол дараах байдлаар хэлэх биз.

“хоолны амтыг идэн байж мэддэг

Ажлын сайхныг хийн байж мэддэг”

Нэг талаас хэлц үг бүрийг тохирох хэлц үгээр дүйцүүлээд байвал сонсож, уншиж байгаа хүнд сонсголонтой, уншигтай байдаг. Нөгөө талаас яруу сайхан орчуулгаар орж ирсэн хэллэгээр аливаа хэлний үгийн сан үргэлж баяжисж байдаг билээ. Тэгвэл ямар үед орчуулах, ямар үед дүйцүүлэх үү? гэдэг асуудал аяндаа гарч ирнэ.

Би дараах саналыг дэвшүүлэх байна.

Үүнийг ишидэхийн өмнө гадаадын хэлц үгийн гарал үүсэл, анхны болон шилжсэн утгатай нь танилцаж, монгол хүнд хамгийн ойлгомжтой орчуулга хийх хэрэгтэй. Шаардлагатай үед зүүлт хийн тухайн нүүрийн доод талд тайлбарлаж болох юм. Хэрэв орчуулгын аль нэг хувилбар монгол хүний сэтгэлд бууж байвал, тэр хэвээр нь авах, харин төдий л амархан ойлгогдохгүй, уншигч, сонсогч хүн эргэлзэхэд хүрч байвал зохих монгол хэлц үгээр дүйцүүлэх зарчмыг баримтлах нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Zusammenfassungen und Schlussfolgerungen

Die meisten Redewendungen einer Sprache entstanden in der früheren Zeit und im Laufe der Zeit verloren einige davon ihre ursprünglichen Bedeutungen und beinhalten neue Bedeutungen. Sogar ersetzten sich manche Wörter durch andere Wörter. Hierbei spielt die ähnliche oder gleiche Laute des einzelnen Wortes eine große Rolle.

Der idiomatische Ausdruck hat folgende Besonderheiten:

- Kein vollständiger Satz,
- der Inhalt der Wörter hat meistens eine andere Bedeutung als was sagen will.

Man konnte mittels der Betrachtung der jeweiligen Redewendung ihre Entstehungszeit vermuten und sogar festlegen, was für das richtige Verstehen sehr wichtig ist. Deswegen sagt man: **“nicht die Wörter, sondern den Inhalt übersetzen”**. Das betrifft besonders die Redewendungen. Beim Übersetzen eines Gespräches oder bei der Übersetzung eines Textes soll man folgende Prinzipien beachten:

- Den Inhalt des ursprünglichen Textes genau wiedergeben,
- es muss in der Zielsprache verständlich, klangvoll und leserlich sein,
- wenn es geht, kein Wort auslassen oder zu zuführen.

Nicht nur die fremdländischen Redewendungen, sondern auch die Redewendungen der Muttersprache soll man forschen und richtig verstehen. Es gibt ähnlich oder gleiche Redewendungen in verschiedenen Sprachen, wie z.B.: “ein geschenktes Gaul guckt man nicht in den Maul” sagen die Deutschen, Mongolen sagen auch das gleiche. Wo zuerst diese Redewendung entstanden wurde, weiß man nicht. Solche Redewendung braucht man nur übersetzen. Man braucht diese Redewendung nicht durch eine andere Redewendung ersetzen.

Ein anderes Beispiel: Im Deutschen gibt es eine Redewendung, "glatt wie ein Aal sein". In diesem Fall wird die titulierte Person als raffiniert und gerissen beschrieben, der es immer wieder gelingt, sich "aalgleich" aus jeder Situation herauszuwinden. Bei ähnlichem Fall wird ein Mongole "олби огтоно"¹⁸⁴ шигэ бутамтамгай" (wie eine Ratte, die schnell aus dem Wege verschwindet) sagen. Noch ein anderes Beispiel: "Der Appetit kommt beim Essen" (хоолны сайхныг идэн байж мэддэг). Ursprünglich war diese Redewendung auf das Essen bezogen. Aber man verwendet sie jetzt im übertragenen Sinn auf der Arbeit bezogen. Das kann für die Mongolen ein bisschen unverständlich sein, daher sollte sie durch ein Äquivalent ersetzt werden. Aber ein passendes Äquivalent zu finden ist schwer.

Ein Mongole wird in folgender Weise sagen.

"хоолны амтыг идэн байж мэддэг

Ажлын сайхныг хийн байж мэддэг"

(durch das Essen weiß man wie das Essen schmeckt,

beim Tun merkt man wie gut eine Arbeit ist.)

Einerseits hilft sich besser, wenn fremdländische Redewendungen durch ein Äquivalent ersetzt werden. Andererseits soll der Wortschatz einer Sprache durch die neuen Redewendungen aus einer gut gelungenen Übersetzung ständig bereichert werden. Da taucht die Frage auf, wann soll man übersetzen und wann soll man ersetzen?

Ich werde folgendes vorschlagen. Bevor man sich darüber entscheidet, soll man die fremde Redewendung genau analysieren. Man soll den ursprünglichen Sinn, die Bezogenheit der Redewendung betrachten. Danach muss man die Redewendung übersetzen, zwar in verschiedenen Formulierungen. Wenn eine Formulierung für die Mongolen verständlich genug ist, soll man sie als endgültige Übersetzung übernehmen. Wenn keine davon passt, muss man nach einem passenden Äquivalent suchen. Ich unterbreite den Dolmetschern und Übersetzern obiges Vorgehen bei einer Übertragung von einer Redewendung.

Энэ сэдэвт хоёр асуудал хөндөгдөж байна. Үүнд:

- Нэгд хэлц үг, түүний онлог,
- Хоёрт орчуулга хийгээд хэлц үгийг орчуулах.

Хэлц үг нь ерийн үед олон үгээр тайлбарлаж, илэрхийлэх санааг хэлж хэвшсэн цөөн хэдэн үгээр илэрхийлэхийг хэлнэ. **Хэлц үг** нь тухайн санааг товч тодорхой, илэрхийлдгээрээ сайн талтай бөгөөд алив өгүүлбэрт хэлц үгийг оруулах аваас тэр газраа эрдэнийн чулуун шигтгээ мэт гялалзаж байдаг билээ.

Өвөрмөц хэлц¹⁸⁵ гэдэг бол гагцхүү тухайн үндэстний хэлэн дэх бүрэлдүүлсэн үгийн утга алдагдаад, нэгэн нэгдмэл утга гаргах болсон тогтвортой нийлэмж үг юм. Алив хэлц үг нь тогтсон дараалал бүхий цөөн хэдэн үгнээс бүрдэх бөгөөд тэдгээр үгийн утга нь гаргах гэсэн санааг илэрхийлдэггүй билээ. Тийм учраас хэлц үгийг орчуулахын өмнө уг үгийн гарал үүсэл, илэрхийлэх гэсэн санааг сайн ойлгосон байх шаардлагатай. Жишээ нь "нүүр тахлах" гэдэг хэлц үг "аргацаах", "аргалах" гэсэн санааг илэрхийлэх ажээ. "гар чанга" гэдэг хэлц үг гартаа тэнхээтэй гэсэн биш, харин

¹⁸⁴Олби огтоно ist eine Ratte, die sich im ruck zuck aus dem Wege verschwindet.

¹⁸⁵Готовын Аким "Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь"

“харамч” гэсэн санааг гаргадаг байна. Ингэхлээр хэлц үгийн утга гаргах гэсэн санаанаасаа өөр байгаа нь харагдаж байна.

Өвөрмөц хэлцийн онцлог:

- Хоёроос дээш үгээс бүтэх боловч утгын хувьд нэгэн бүхэл болж, нэг утгыг илэрхийлнэ.
- өвөрмөц хэлцийг ганц нэгээр нь салгаж болохгүй,
- түүнийг гадаад хэлнээ үгчлэн орчуулж болдоггүй¹⁸⁶

Монголчууд нэн эртнээс үндэсний бичиг үсэгтэй болж, аливаа үгийн бичих хэлбэр нь хөгжлийнхээ явцад төгөлдөржин **нэг мөр болж** тогтсон, үг бүрийн язгуур нь өөрийн гарал үүслээ илтгэдэг, ижил дуудлагатай боловч үгийн гарал нь өөр өөр үгийг ондоо ондооноор бичдэг билээ. Мөн ахас, ихэс, дээдцүүлээ хүндлэх үг, хэллэгийн ариун баялаг сантай юм. Дэлхий дээр өөрийн гэсэн бичиг үсэгтэй орон цөөхөн бөгөөд үүний нэг ойрын жишээ л гэхэд тавь гаруй үндэстэн, ястантай Хятад улс үндэсний дөрвөн бичгийг мөнгөн дэвсгэрт дээрээ бичсэн байдгийн нэг нь **монгол бичиг** билээ.

Монголчууд эртний бичгийн соёлтой үндэстний хувьд мөн эртний бичиг үсэгтэй оронтой харьцаатай байж тэр бичгийн соёлтой улсаас ном зохиолыг нь орчуулж, тэдний соёлтой танилцаж иржээ.

Монголчууд нүүдэлчин, малчин удамтай хүмүүсийн хувьд мал аж ахуйн холбогдолтой үг хэллэгээр нэн баялаг билээ. Адууны зүс, насыг монголчууд хамгийн олон янзаар хэлдэг хэмээн ярьдаг. Тэр чиглэлийн хэлц үг ч олон.

Манай улс суурин соёлд шилжин амьдрах арга барил нь өөрчлөгдөхийн хэрээр урд өмнө нь их л өөр төсөр байсан хэлц үг жирийн нэг зүйл мэт болох тал ч байдаг байна. Дундат зууны үед европоос Монголд ирж Монголчуудын тухай бичиж үлдээсэн ном зохиол нь их боловч Монголоос Европод очиж, хэлийг нь сурсан хүмүүсийн талаар мэдэх зүйл ховор ажээ. Хувьсгалаас өмнө Европод гараад нилээд хэдэн хэл сураад Монголдоо ирсэн хүн бол монголын анхны эсперанточ, эсперанто хэлний анхны сурах бичгийг монгол хэлээр бичсэн **Хаянхярваа** гуай билээ.

Харин европын хэлнээс ном зохиол эх хэлнээ хөрвүүлэх өргөн хүрээтэй ажлыг 1926 онд Герман улсад сурахаар явсан анхны 26 эхлүүлжээ. Түүнээс хойш манай улсын 30 000 гаруй иргэн энэ улсад урт богино хугацаагаар дунд дээд сургуульд суралцаж, герман хэлийг их бага ямар нэг хэмжээгээр сурч ирсэн гэдэг. Энэ дундаас герман хэлээр зохиол бүтээлээ туурвидаг зохиолч хүртэл бий болжээ. Германд боловсрол эзэмшсэн тува угсааны **Ч.Галсан** герман хэлээр 30 гаруй роман бичиж, гадаадын зохиолчдод олгодог олон шагнал авсан болой.

Нүүдэлчин түмэн эртнээс нааш алдсан малаа эрэх, отор нүүдэл хийх, билчээр нутаг хайх зэргээр хөрш зэргэлдээ орноор их явж, хөрш зэргэлдээ болон түүний цаадах орон улсаар яван тэдний хэлийг сурах, улмаар тэр орны аман зохиолыг яриулж, сонсож, түрүү олон явж, тэр орны хэлийг сурсан нэг нь шинээр очсон нэгэндээ хэлмэрчлэх, улмаар тэр орны бичгийг суран, ном зохиолыг нь амтархан уншиж ойлгон, тэдгээрээс эх хэлнээ орчуулдаг байсан нь дамжиггүй.

Хэлмэрчлэх гэдэг хоёр хүний хооронд хэл залгуулах төдийхнөөр эхэлж байсан бол улс хоорондын харилцаа холбоо хөгжихийн хэрээр нарийн мэргэжлийн нэг болж, хоёр

¹⁸⁶ Мөн тэнд

орны удирдагч нарын чухал уулзалт яриаг хэлмэрчлэх зэргээр нарийсч "...өөр өөр хэлээр хэлэлцэгсэдийн яриа хөөрөө зэргийг нэг хэлнээс нөгөө хэлэнд хэлмэрчлэх, орчуулах шаардлага алхам тутамд гарч орчуулгын ажил нь орчин үеийн хүн төрөлхтний амьдралын жинхэнэ хэрэгцээ нэгэнт болсон байна"¹⁸⁷. Энэ ажил тал бүрийн мэдлэг шаардсан, өндөр хариуцлага бүхий, итгэл хүлээсэн ажил мэргэжил болж хувирчээ. Гадаад хүний хэлж, ярьж байгаа үг, яриаг эх хэлнээ хөрвүүлэх хэлмэрч хүний хувьд харьцангуй хялбар байдаг ч амьдрал дээр ярьж байгаа хүний яриаг өөрийнх нь **хэлмэрч** нөгөө талд хэлмэрчилж өгөх нь түгээмэл билээ. Яагаад гэвэл миний яриаг миний хэлмэрч л илүү найдвартай итгэлтэй хэлмэрчилнэ. Тэгээд ч өөрийнхөө хүний ярих **арга барилыг** илүү мэддэг, түүнийхээ яриаг хэлмэрчилж **гаршсан** байна. Ямар ч тохиолдолд хэлмэрч хүн сонсож, ярьж байгаа хоёр хэлээ төгс сайн мэддэг, ижил утгатай үгсийг маш сайн мэддэг, хоёр хэлний хэлц үг, зүйр цэцэн үгийг сайн мэддэг байх нь чухал. Хамгийн чухал нь хоёр орны ард түмний зан заншил, түүхийг нарийн мэддэг байх шаардлагатай. Хэлмэрчлэх гэдэг **хур мэдлэгээрээ, цээжнийхээ багтаамжаар** л давах ажил. Шууд л тухайн мөчид цээжинд орж ирснээр хэлэхээс биш лавлан харах, хүнээс асуух, сүүлд засаж залруулах боломжгүй билээ. **Хэлмэрч** хүний бас нэг онцгой чадвар бол хоёр зүйлийг зэрэг хийх явдал юм. Энэ бол сонсохын зэрэгцээ ярих болой. Өөрөөр хэлбэл хүний ярьж байгааг тухайн мөчид цээжлэхийн зэрэгцээ түрүүчийн мөчид цээжилсэн зүйлээ ярих чадвартай байна гэсэн үг.

“Орчуулга гэдэг бол нэг хэлээр илэрхийлсэн санааг нөгөө хэлний бүх хэрэглэгдэхүүнийг ашиглан бүрэн төгс гаргах бүтээлч хөдөлмөрийн үр дүн мөн. **Хэлний бүх хэрэглэгдэхүүн** гэдэг ухагдахуунд авиа зүй, үгийн сан, өгүүлбэр зүй, найруулга зүйд хамаарах бүх хэрэглүүр багтана. Ийм учраас нэг хэлээр байгаа зохиол бүтээл буюу үг хэллэгийг нөгөө хэлээр уншигч буюу сонсогч хүнд хамгийн дөт дөхөм ойлгомжтой, бүрэн зөв илэрхийлэн гаргах нь аль ч орчуулагчийн үндсэн үүрэг байдаг.”¹⁸⁸

Ярьж байгаа хүн хэлц үг хэлэх, эрт, эдүгээгийн уран зохиол, улс төрч, алдартай хүмүүсийн хэлсэн үг, тэр ч бүү хэл нэрт яруу найрагчийн бүтээлээс ишлэл авах нь цөөнгүй тул хэлмэрч хүн тал бүрийн мэдлэгтэй, цээж сайтай, саруулхан ухаантай, сийрэгхэн сэтгэдэг байх хэрэгтэй нь мэдээж.

Хэлмэрч хүн хоёр орны үлгэр, домог, хэлц үгийн гарал үүслийн түүхийг сайн мэддэг байх шаардлагатай. Энэ талаар нэг жишээ татъя:

- **“auf den Hund kommen”** (дээр руу нохой очих,) гэсэн герман хэлц үг байна.

Өнгөвчхөн харвал нохой руу очиж уруулах нь уу даа гэж бодогдмоор ...

Гэтэл тийм биш ажээ. Германчууд мөнгөө нэг жижиг модон хайрцаганд хадгалдаг байжээ. Тэгээд мөнгөө нохойгоор мануулж байгааг бэлгэдэн цаасан дээр нохой зуруулан хайрцагныхаа ёроолд хийн дээрээс нь мөнгөө нэг нэмж хийж, нэг авч байдаг байжээ.

Нэг өдөр мөнгөө авах гэсэн гэнэт нохойн зураг гараад ирвэл мөнгө дууссан хэрэг болно. Тэгээд нохойндоо хүрсэн шүү, бүр нохойн зурагтаа тулсан шүү хэмээн хэлнэ. Тэгэхлээр нөгөө дээрх хэлц үгийн утга бол мөнгө нь дуусаад **“нохойндоо хүрэх”** ажээ.

¹⁸⁷ Солонгос хэлний багш Б.Мөнх-Эрдэнэ

¹⁸⁸ Солонгос хэлний багш Б.Мөнх-Эрдэнэ

Монголчуудын хэлдгээр бол “түрийвчээ сэгсрэх”, мөнгөний “авдарны ёроол гарах” гэсэн үг ажээ.

Германы “нохойндоо хүрэх” гэсэн хэлц үгийг монголын “түрийвчээ сэгсрэх” гэсэн хэлц үгээр дүйцүүлж болох нь гэсэн санаа төрж байна.

Бас нэг жишээ авч үзье.

“Glatt wie ein Aal sein” (Могой загас шиг гулжигнасан амьтан) Бүр эрт дээр үеэс загасчид могой загасыг бариад авахад гулжигас гээд гараас мултараад явчихдаг байсан хэрэг. Тэгээд баригддаггүй тэр амьтныг бахдан магтахаасаа илүү муу хэлж хараах нь олонтаа байжээ. Мөн амьдрал дээр алив нэг ажил болохоор аргалж, бултаад алга болдог хүн байдаг. Түүнийг германы загасчид ёстой нэг могой загас шиг мултраад зайлдаг амьтан хэмээн үл тоодог байсан учраас өөртөө хэрэггүй юмнаас аргалаад зайлж дөнгөдөг хүнийг “могой загас шиг гөлчгөнөж мултарсан амьтан” хэмээдэг бол, мөн тийм хүнийг монгол оронд түгээмэл байдаг олив огтонотой жишин тэр ч ёстой “олби огтоно шиг бултаж орхидог амьтан” даа гэгцгээнэ.

Тэгвэл өөрт нь ашиггүй юм болоход “алга урвуулах зуур” алга болж орхидог хүнийг германчууд “могой загас шиг гулсамтгай” гэдэг бол монголчууд “олби огтоно шиг бултамтгай” гэдэг байх нь. Өөр нэг жишээ авъя.

“Der Appetit kommt beim Essen” (хоолны сайхныг идэн байж мэддэг)

Алив нэгэн хоолыг амсаж үзээгүй байж “өө би идэхгүй” гэх хүн байдаг, харин амсаж үзчихээд ахиад нэг нэмүүлье гэх нь бий. Түүний нэгэн адил алив ажил тийм ч сонирхолгүй мэт харагдаж болох ч хийгээд үзэхэд тун дажгүй санагдаж болох шүү дээ. Хоолыг “идэн байж амтыг нь мэдэрдэг” гэсэн үгийг германчууд шилжсэн утгаар алив ажил үйлс дээр бас хэрэглэдэг. Монгол хүн бол

“хоолны амтыг идэн байж мэддэг,

ажлыг амтыг хийн байж мэдэрдэг” гэх биз.

Арай шилжсэн утгаар бол хүн “ажлыг хүн голохгүй, ажил хүнийг голдог” гэсэн үг ч байдаг.

Сүүлийн үед хэлц үгийг түүвэрлэж, судалсан эрдэмтэд цөөнгүй ажээ. Др. Ж.Бат-Ирээдүй хэлц үгийг нэр төвт, үйл төвт¹⁸⁹ гэж ангилсан байна.

Ж. Бат-Ирээдүй хэлц үгийг “гар нийлэх”, “ганзага нийлэх”, зэрэг үйл төвт, “аавын цээж”, “архины лүү” зэрэг нэр төвт хэмээн хоёр ангилжээ.

Хэлц үгийг оновчтой ангилах нь толь бичиг зохиоход давхардуулж оруулахгүй, хийдүүлж орхихгүй байх сайн талтайгаас гадна хэрэглэгч тодорхой нэг хэлцийг хайж олоход хялбар дөхөмтэй байдаг билээ.

Герман хэлц үгийг орчуулах явцад миний ажигласан зүйл гэвэл:

1. Ижил санааг адил зүйлээр илэрхийлсэн хэлц үгс монгол, герман хэлэнд хоёуланд байна:

- 1.1. “schlafen wie ein Murmeltier” (унтах яг нэг тарвага)- “тарвага шиг унтах”

¹⁸⁹ Ж.Бат-Ирээдүй Монгол хэлний хэлц үгийн санд оршил бичсэн Проф.Др. Ж.Баянсан

- 1.2. "Liebe macht blind" (хайр дурлал хийх сохор) – **"Хайр сэтгэл харалган"** болгодог
- 1.3. "Etwas wie seinen Augapfel hьten" (-ыг яг өөрийн нүдний цэцгий хамгаалах) – **"Нүдний цэцгий мэт"** хайрлах Sich nach der Decke strecken" (өөрөө руу – д хөнжил дэлгэх) – **"Хөнжлийнхөө хэрээр хөлөө жийх", "Адууныхаа хэрээр нсгэрэх"**

- 1.4. "Ein geschenktes Gaul guckt man nicht in den Maul" (нэг бэлгэлсэн морь харах хүн үгүй ам руу) – **"бэлгийн морины шүдийг үздэггүй"**

Нэгдэх жишээг авч үзвэл герман монгол оронд хоёуланд нь тарвага гэдэг ичдэг, ичээндээ ороод их унтдаг амьтан байдаг. Бас их нойртой, унтаж ханадаггүй хүн ч хаа сайгүй л байдаг. Тэгэхлээр их нойртой хүнийг хоёр орны хүмүүс өөрсдийн сайн мэддэг тарвагатайгаа зүйрлүүлсэн хэрэг байна. Хоёр дах жишээ хүн байгаа газар хайр сэтгэл байна. Хайрласан хүнийхээ алдаа дутагдлыг олж харахгүй байх нь түгээмэл билээ. Гуравдах жишээ хүний хүсэл мөрөөдөл хэдий их ч гэлээ түүнийг нь нөхцөл боломж, эрдэм мэдлэг, бэл бэнчин үргэлж хясаж байдаг. Түүнийг монголчууд **"тэгнэ ингэнэ гэхийг тэнхээ мэднэ, түүгээр үүгээр явна гэхийг тэмээ мэднэ"** гэж онож хэлсэн байдаг. Мөн орчин цагт **"араамандаа жаажигнах"** гэсэн хэлц үг нилээд газар авч байна. Хөлөө жийгээд тэнэгэр унтах сайхан ч хөнжил маань богинохон бол хөл даарна, тэгэхлээр атираад унтах хэрэг газар сайгүй гардаг биз ээ.

Дээрх хэлц үгсийг бараг шууд орчуулж болох бөгөөд ямар нэгэн монгол хэлц үгээр дүйцүүлэх шаардлагагүй болж байна.

2. Ижил санааг монгол, герман ард түмэн өөрийнхөөрөө илэрхийлсэн өвөрмөц хэлц үгс:

- 2.1. "Wer A sagt, muss auch B sagen" (хэн А гэвэл, тэр бас Б гэх ёстой) – **"За гэвэл ёогүй";**

ажил хийвэл дуустал...

- 2.2. "Der Apfel fällt nicht weit vom Baum" (алим модноосоо хол унадаггүй).- **"эх нь хээр алаг бол унага нь шийр алаг", "ороо нь ороогоороо, жороо нь жороогоороо"**
- 2.3. "Keiner Fliege etwas zu Leide tun können" (ямар нэг ялаанд зовлон учруулж дөнгөхгүй) – **"хорхойд хоргүй", "мөрөөрөө" амьтан**
- 2.4. Mit einer Klappe zwei Fliegen schlagen (нэг цохиураар хоёр ялаа тогших) – **"Нэг сумаар хоёр туулай буудах"**
- 2.5. "Auf jeden Abend folgt ein Morgen" (орой бүхний араас өглөө болдог) – **"Юм нэгээр дуусдаггүй",**
- 2.6. "Einen Altweibersommer genieЯen" (чавганц нарын зуныг хүртэх) – **"намрын шар наранд налайн суух"**
- 2.7. "Ein Auge auf etwas werfen" үгчилбэл "нэг нүдээ ямар нэг юм руу шидэх" гэсэн герман хэлц ньманай **"нүдээ бүлтэртэл ширтэх", "цоо ширтэх", "харц шидэх"** гэсэн хэлцтэй дүйх ажээ.
- 2.8. "Mit einem lachenden und einem weinenden Auge" энэ хэлц Шекспирийн Гамлет жүжгийг герман хэлнээ орчуулахад орж ирсэн байна. Энэ нь манай **"нааш харж инээж, цааш харж уйлж"** гэсэн хэлцтэй дүйх биз ээ.

Эдгээр хэлцийг монгол хэлнээ буулгахад монгол хэлний хэлц үгээр тун хялбархан дүйцүүлж болох ажээ.

3. Ижил санааг монгол, германы ард түмэн зан заншил, ан амьтантай холбоотой өөр өөр хэлбэрээр илэрхийлсэн өвөрмөц хэлц үгс:

31. “Aalglatt sein” (могой загас шиг гөлчгөр), хүнийг муу тал руу нь хэлэхэд энэ зүйрлэлийг хэрэглэх бөгөөд үүнийг дараах маягаар буулгаж болох мэт. “Долоо шархадсан чоно”, “доль цохьсон”, “олби огтоно” гэсэн санаа юм.

32. “Jemandem um den Bart gehen” (хэн нэгэнд тойрох –ийг сахлыг явах) – “Тал засах”, “долигонох”

Өвөрмөц хэлц үгийг хэлмэрчлэх, орчуулах хамгийн хэцүү, яагаад гэвэл өвөрмөц хэлц тийн илэрхийлэл нь нэг өөр, гаргах гэсэн санаа нь бас өөр байдаг билээ.

33. “Wo sich Fuchs und Hase gute Nacht sagen”(үнэг, туулай хоёр бие биендээ сайхан нойрсоорой гэдэг газар) хаа нэгтээ нэг газар байх нь, тэр газар үнэг, туулай гэх мэт амьтан айл, хөрш айван тайван амьдардаг, тэр байтугай оройд бие биендээ сайхан нойрсоорой гэгцгээнэ. Тийм газар бол хүн амьтангүй эл хуль газар байж таараа, “алс буйд газар”, “зах хязгаар нутаг”-г гэж хэлэх буй заа.

34. “Ein falscher Fuffziger sein” (хуурамч тавьт) хуурамч дэвсгэрт гэдэг үгнээс гаралтай ажээ. Харин шилжсэн утгаар нь “худлаа сайхан загнасан”, “худлаа инээсэн” наль наль хийсэн”, “итгэж болохгүй” гэсэн санааг илэрхийлдэг ажээ.

35. “Jemanden alle machen” хэн нэгнийг гүйцээж орхих, хэн нэгнийг зүйл дуусгах, хэн нэгнийг болгож тавих гэсэн санаа нь яг үнэндээ уурандаа л зүгээр хэлж байгаа сүрдүүлэг билээ. Тэр нь монгол хэлэнд “гүйцээж орхих”, “зүйл дуусгах”, “болгож тавих” гэх зэрэг үгээр буулгаж болох юм.

36. “Einen langen Arm haben” урт гартай байх гэсэн үг. Энэ нь нөлөө ихтэй, эрх мэдэл ихтэй гэсэн санааг аль эрт цагаас илэрхийлж иржээ. Хууль урт гартай шүү ч гэдэг. хуулийн хараанаас гадуур үлдэх нь үгүй гэж ч болмоор. Манайд бол түүний “гар нь үл хүрэх газар үгүй” гэж хэлж болмоор.

37. “aufmübeln” бүх тавилгаа шинэчлэх, сайжруулах гэсэн утгатай мужааны ярианаас гаралтай боловч орчин үед шилжсэн утгаар “jemanden aufmübeln” гэдэг хэлц үг гарч ирсэн нь хэн нэгнийг ямар нэгэн зүйлд биширтэл ярих гэсэн санааг илэрхийлэх болсон байна. Манай “сэнхрүүлж орхих”, “бишрүүлж орхих” гэсэн хэлц үгтэй адил ажээ.

Хэлмэрч, орчуулагчид дорхи гурван үндсэн шаардлага тавигдана.

- Буулгасан хэлэн дээр сонсож, уншиж байгаа хүнд яруу сонсголтой байх,
- Зохиогчийн гаргасан санааг өөрчилж гажуудуулаагүй байх,
- Онцын шаардлагагүй тохиолдолд үг, хасаж нэмэхгүй байх

Үүнээс үндэслэн орчуулга бол нэг хэлээр илэрхийлсэн санааг нөгөө хэлний бүх эрэглэгдэхүүн¹⁹⁰ ийг ашиглан бүрэн төгс гаргах бүтээлч хөдөлмөрийн үр дүн мөн.

Үйм маягийн хэлц үгийг утгачлан орчуулахад монгол хүний сэтгэлд төдийлөн сайн үүхгүй, тохирох хэлц үгээр дүйцүүлэхэд нилээд цаг зав шаардах билээ.

Элц үг бүрийг тохирох үгээр дүйцүүлээд байвал уншиж байгаа хүнд ойлгомжтой бодий ч уншигчдад гадны соёлтой танилцах боломж олгохгүй, гадны соёл аливаа мэнд орж ирэх боломжгүй болох билээ. Гэтэл аливаа хэлний үгсийн сан чадамгай орчуулгын гадны үг, хэллэгээр үргэлж баяжиж байдаг билээ.

Эерхээс үндэслэн гадаадын хэлц үгний гарал үүсэл, анхны болон шилжсэн утгатай нь ашиглаж, монгол хүнд хамгийн ойлгомжтой орчуулга хийх хэрэгтэй. Хэрэв тэр нь монгол хүний сэтгэлд бууж байвал, тэр хэвээр нь авах, харин төдий л амархан ойлгогдохгүй байвал монгол хэлц үгээр дүйцүүлэх зарчмыг баримтлах нь зүйтэй гэсэн талыг дэвшүүлж байна.

¹⁹⁰ авиа зүй, үгийн сан, өгүүлбэр зүй, найруулга зүйд хамаарах бүх хэрэглүүр

Энэ илтгэлд орсон хэлц үгс:

- авдарны ёроол гарах,
- араамандаа жаажигнах,
- ажлын амтыг хийн байж мэдэрдэг,
- арга барил,
- бишрүүлж орхих,
- болгож тавих,
- бэлгийн морины шүдийг үздэггүй,
- гадарлах,
- ганзага нийлэх,
- гар нийлэх,
- гар нь үл хүрэх газар үгүй
- итгэж болохгүй этгээд
- муу санаатай амьтан,
- нэг мөр болгох,
- олби огтоно шиг бултамтгай,
- сэнхрүүлж орхих,
- түүгээр үүгээр явна гэхийг тэмээ мэднэ,
тэгнэ ингэнэ гэхийг тэнхээ мэднэ,
- түрийвчээ сэгсрэх,
- Хайр сэтгэл харалган,
- хоолны амтыг идэн байж мэддэг,
ажлын сайхныг хийн байж мэдэрдэг.
- утгаа алдах,
- эх нь хээр алаг бол унага нь шийр алаг;

Түлхүүр үгс: Галсан, монгол бичиг, нүүдэлчин, орчуулга, Хаянхярваа, хэлний бүх хэрэглэгдэхүүн, хэлмэрч, хэлмэрчлэх, хэлц үг

Ном зүй:

- Аким Г. Монгол өвөрмөц хэлцийн тайлбар толь
- Бат-Ирээдүй Ж. Монгол хэлний хэлц үгийн сан
- Бат-Ирээдүй Ж. Ариунжаргал Г. Монгол хэлний ойролцоо,эсрэг утга хэлц үгийн сан
- Цэрэнчулуун Герман хэлний өвөрмөц хэлц үгс
- Сүхбаатар Монгол ардын аман зохиол, хэлц үгс